



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

「Нийслэлийн өмчид барилга байгууламж
бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон, нийт 390,168,209.00 (гурван зуун ерэн сая нэг зуун жаран найман мянга хоёр зуун ес) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100384

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ (төгрөгөөр)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Ус түгээх байр	Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Хужирбулангийн 5 хэсэг	2023	69,214,816	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
2		Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 13-р гудамж	2023	101,309,594		
3		Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 4-р гудамж	2023	113,854,533		
4		Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 7-р гудамж	2023	105,789,266		
Нийт дүн				390,168,209		